

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2008 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн байгууллагын
дүрмийн сангийн доод хэмжээг
шинэчлэн тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг хавсралтад зааснаас доошгүй байхаар тогтоосугай.

2. Тусгай зөвшөөрөлтэй банк бус санхүүгийн байгууллагууд болон тус тогтоолыг гарахаас өмнө банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тухай хүсэлтээ ирүүлсэн хуулийн этгээд 2009 оны 6 дугаар сарын 30-ны дотор дүрмийн сангийн доод хэмжээгээ энэ тогтоолд заасан хэмжээнд хүргэхийг Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлэгчид, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-г, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

/Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 147 дугаар тогтоолоор орсон өөрчлөлтийг тусгав/

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ДҮРМИЙН САНГИЙН ДООД ХЭМЖЭЭ

/сая төгрөгөөр/

| Үйл ажиллагааны төрөл | Аймгийн төвийн сумаас бусад суманд | Аймгийн төвийн сум | Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум | Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүрэг | Улаанбаатар хотын бусад дүүрэг |
|---|------------------------------------|--------------------|---|---|--------------------------------|
| 1. Зээлийн үйл ажиллагаа | 20.0 | 50.0 | 200.0 | 200.0 | 400.0 |
| 2. Факторингийн үйлчилгээ | | | | | |
| 3. Төлбөрийн баталгаа гаргах | | | | | |
| 4. Гадаад валютын арилжаа | 100.0* | | | | |
| 5. Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх | 20.0 | 50.0 | 200.0 | 200.0 | 400.0 |

| | | | | | |
|--|------|-------|-------|-------|--------|
| 1. Цахим төлбөр тооцоо, мөнгөн | 50.0 | 100.0 | 500.0 | 500.0 | 1000.0 |
| 2. Итгэлцлийн үйлчилгээ | | | | | |
| 3. Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах | | | | | |
| 4. Богино хугацааны санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх | | | | | |

-- ооОоо --

*Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 147 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан

